


Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна

Сайхан сэтгэлт Самари хүн



Зохиогч: Edward Hughes
Зураглаач: M. Maillot; Lazarus
Найруулсан: Ruth Klassen; Sarah S.

Alastair Paterson

Орчуулсан: Damdin Horolsuren
Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

BFC
PO Box 3
Winnipeg, MB R3C 2G1
Canada

©2022 Bible for Children, Inc.
Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.

1



"Багшаа! Би мөнхийн
амийг авахын тулд яах
ёстой вэ?" гэж нэгэн
хуулийн багш Есүсийг
сорихоор асуужээ.
Есүс
"Бурханы

хуульд энэ тухай юу
гэдэг вэ?" гэж хариулав.

2

"Бурхан Эзэнээ хайрла хөршөө хайрла" гэсэн байдаг гэж өнөөх хүн хариулав. Тэр "Гэвч хэн миний хөрш вэ?" хэмээн асуув.



3

Түүний асуултад хариу болгож Есүс Иерусалемаас Иерохо орохоор явсан нэгэн хүний тухай түүх ярив. Тэр хүн уруу дээрэмчид дайрчээ.



4

Дээрэмчин түүний бүх зүйлийг нь булаан авч хувцсыг нь хүртэл тайлан авчээ. Тэд түүнийг хүндээр шархдуулж түүний хагас үхсэн биеийг замын хажууд хаяжээ.



5

Азаар нэгэн тахилч хүн тэр замаар ирж явав. Тэр шархдсан хүнд туслах нь гарцаагүй. Үгүй ээ! Тэр тахилч




цустайгаа холилдсон

тэр хүнийг хараад өөр замаар тойроод явчлав.


6

Удалгүй нэгэн хүн тэр замаар ирж байв. Тэр бол сүмд тахил өргөдөг Левит хүн байв. Тэр ирээд бэртсэн өнөөх хүнийг харсан ч туслалгүйгээр явчлав.




7

Эцэст нь тэр замаар Самари хүн ирж байв. Иудей хүмүүс Самари хүмүүсийг үзэн яддаг байжээ.



8


Есүсийн яриаг сонсож байсан хүмүүс Самари хүнийг ярих үед түүнийг баатар гэж төсөөлөө ч үгүй байв. Гэвч тэр баатарлаг хүн байлаа. Самари хүн зогсон түүнд



туслан түүнийг асрав.


9

Самари хүн өвдөглөн сууж түүний шархыг боож өгөв. Тэгээд өвчтэй хүнийг өөрийн илжгэндээ тэгнэлээ.



10

Замаар явсаар нэгэн дэн буудалд ирж Самари хүн өнөөх өвчтэй хүнийг шөнөжингөө асарчээ.





11

Өгөө болоход тэр буудлын эзэнд мөнгийг нь төлөөд өвчтэй хүнийг сайжиртал асарч байгаач хэмээн захижээ.



12

Энэ түүхийг ярьж дуусаад Есүс "Өвчтэй хүний хөрш нь хэн бэ?" гэж асуув.



13



Хуулийн багш "Түүний хөрш энэрлийг үзүүлсэн Самари хүн" гэв.

14

"Явж түүнтэй адил үйлд"
хэмээн Есүс хэлэв. Хөрш
бол тусламж хэрэгтэй
хэн нэгэн юм.
Бид тэдгээр
хүмүүст туслан
хайраа харуулах
хэрэгтэй. Үүнчлэх
үйлдэхэд Бурхан
баярладаг юм.



15

Сайхан сэтгэлт Самари хүн

Бурханы үг Библиээс авсан түүх

Лук 10

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."
Дуулал 119:130

16

Төгсөв

46



60

17

Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг
өорийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан
сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их
хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс
шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд
илгэсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан!
Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр
таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх
болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.

Хэрвээ та энэ үнэнд итгэж байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:
"Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон миний гэмийн төлөө
үхсэн гэдэгт мөн одоо та амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд
орж ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос эхлээд шинэ
амьдралаар амьдарч нэг өдөр тантай хамт мөнхөд байхаар явах
болно. Танд дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө
амьдрахад туслаач. Амен."

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай! Иохан 3:16

18